



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 682

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2021 оны 38 дугаар захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр бий болсон нийт 190,000,000.00 (нэг зуун ерэн сая) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Тээврийн цагдаагийн албанд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Тээврийн цагдаагийн албаны дарга О.Ганбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

132007561

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 4 дугаар сарын 30 -ны өдрийн  
682 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН  
АЛБАНЫ БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Хьюндай соната, DN-8 (автомашин)	ш	2	95,000,000.00	190,000,000.00
	Нийт дүн				190,000,000.00 (нэг зуун ерэн сая)